

Батлав:



О.Мөнхбат / Оюутны хөгжил, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал /

УХД0072 Элсэгчдэд зориулсан чиглүүлэх, танилцуулах үйл ажиллагааны удирдамж

МУИС-д шинээр элсэгчдэд сургууль болон сургалтын орчин нөхцөл, сургалтын журам, бусад холбогдох дүрэм журмууд, хичээл сонголт, Сиси сургалтын систем түүний хэрэглээ, эмнэлэг, номын санг танилцуулах, оюутны байгууллага, сайн дурын клубүүдийг танилцуулах, гишүүнээр элсэх боломж олгох чиглүүлэх, танилцуулах үйл ажиллагааг зохион байгуулдаг.

Монгол улсын их сургуулийн сургалтын журамд хичээлийн жилийн намар, хаврын улирал эхлэхээс өмнөх 7 хоногт тухайн улиралд суралцагч судлах хичээлийн агуулгатай танилцаж, хичээлд бүртгүүлэн баталгаажуулалт хийх Танилцуулах долоо хоногтой байх бөгөөд энэ хугацаа нь танхимын сургалтын долоо хоногт орохгүй гэж заасны дагуу элсэгчдэд зориулсан Чиглүүлэх, танилцуулах долоо хоногийн үйл ажиллагааг Оюутны алба, Бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба хариуцан тухайн Бүрэлдэхүүн сургуулийн захиргаа, Мэдээлэл технологийн алба, Номын сан, Оюутны байгууллагатай хамтран зохион байгуулна.

Хугацаа:

Элсэгчдэд зориулсан Танилцуулах долоо хоногийн үйл ажиллагаа 8 дугаар сарын 25-наас 31-нд ажлын өдрүүдэд үргэлжлэн зохион байгуулагдана.

Бүрэлдэхүүн сургууль бүр Элсэгчдэд зориулсан чиглүүлэх, танилцуулах албан ёсны уулзалтаа зарлан зохион байгуулна.

Чиглүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах

Нэг цэгийн танилцуулга:

Танилцуулах долоо хоногийн турш элсэгчид, эцэг эхчүүдэд туслах, мэдээлэл өгөх, чиглүүлэн зөвлөгөө өгөх үйл ажиллагааг нэг цэгийн үйлчилгээгээр хүргэнэ. Үйлчилгээ МУИС-ийн II байрны А зааланд ажлын цагаар явагдана. Алба хэлтэс бүр үйл ажиллагааныхаа танилцуулга presentation бэлдсэн байх, проектор, компьютер, экран, гарын авлага, мэдээлэл байршуулах тоног төхөөрөмжөө бэлтгэж оролцоно. Сургалтын журам, сиси систем, хичээл сонголттой холбоотой асуудлуудаар зааварчилгааг өгөх тул тухайн сургуулийн ОА, СА-ны ажилтнууд, МТА, Хөтөлбөрийн Зөвлөх багш нар маш сайн мэдээлэлтэй байх. Оюутны байгууллагаас “Чиглүүлэгч оюутан” бүрэлдэхүүн сургуулийн оюутны зөвлөлийг оролцуулах ажлыг ОА зохион байгуулна.

Чиглүүлэгч оюутан нь оюутны албанаас өгсөн зааварчилгааны дагуу хүрэлцэн ирэгсдийг угтах, үдэх, байр, байршил, уулзалт зохих алба, хэлтсийг зааж өгөх анхан шатны чиглүүлэх үүрэгтэй оролцоно.

Номын сан танилцуулга, элсэгчдийг бүлгээр хүлээж авах заал, танхимаа бэлдэх.

8 дугаар сарын 24-ний өдөр Хөтөлбөрийн зөвлөх багш нарт зориулсан танилцуулах уулзалтыг бүрэлдэхүүний СА-аас зохион байгуулна.

Нэг цэгийн танилцуулах үйл ажиллагаа, номын сангийн танилцуулах үйл ажиллагаа руу бүрэлдэхүүн сургуулиуд элсэгчдээ бүлэг бүлгээр нь зохион байгуулж оруулна. Бүрэлдэхүүн сургуулийн онцлогоос шалтгаалан нэмэлт үйл ажиллагаа зохион байгуулах нь нээлттэй.

Гадны оролцогч талууд:

Голомт банк, Хаан банк

Нийгмийн даатгалын газар /Эрүүл мэндийн даатгал, Гэнэтийн ослын даатгал/

Бэлтгэл хангах нь:

Оюутны алба

- Нэг цэгийн танилцуулга хийх хөтөлбөр, хуваарь гаргах
- Оюутны алба, үйлчилгээний ерөнхий танилцуулга
- Шторк
- Мар
- Тэтгэлгийн талаарх мэдээлэл
- Суралцагчийн гарын авлага

Бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба

- Бүрэлдэхүүн сургуулийн танилцуулга
- Бакалаврын сургалтын журам танилцуулга /хөтөлбөрийн танилцуулга, ерөнхий суурийн талаарх мэдээлэл, хичээл сонголт хийх талаарх мэдээлэл/

Мэдээллийн технологийн алба

- Сиси сургалтын систем, түүний хэрэглээ
- Мобайл аппликайшн-ий хэрэглээг танилцуулна

Номын сан

- Номын сангийн үйлчилгээ, түүнд тавих шаардлагын тухай танилцуулга
- Элсэгчид хүлээж авах заал, танхимаа бэлтгэх

Хөтөлбөрийн зөвлөх багш нар

- Хөтөлбөрийн зөвлөх багш нар 2016-2017 оны хичээлийн жилийн бүлэгтэй ажиллах төлөвлөгөөгөө гаргах
- Элсэгчдэд мэдээлэл, зөвлөгөө өгөхөд дэмжлэг үзүүлэх

Санхүү, эдийн засгийн алба


- МУИС-ийн санхүү төсөв, оюутны төлбөр

Оюутны байгууллага, клуб


- Оюутны байгууллага, клубийн танилцуулга

Нийтлэг үйлчилгээ

- Банкны үйлчилгээ
- Нийгмийн даатгал
- Сайн оюутан хөтөлбөртэй холбогдолтой мэдээлэл, лавлагаа үйлчилгээ



2016-2017 оны хичээлийн жилийн “Нээлтийн ёслол”-ын үйл ажиллагааны зохион байгуулалтын тов, мэдээллийг Элсэгчдэд хүргэнэ. Тухайн үед нээлтийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг МУИС-ийн албан ёсны веб сайт дээр дэлгэрэнгүй байршуулсан байна.



Боловсруулсан

Ж.Бадамханд

Хянасан

Б.Алтангэрэл

Оюутны алба